



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн өмчийн  
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Гурванцүүр өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг буулгаж, шинээр өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор байр барих болсонтой холбогдуулан тус газрын баланст бүртгэлтэй, нийт 64,994,142.30 (жаран дөрвөн сая есөн зуун ерэн дөрвөн мянга нэг зуун дөчин хоёр төгрөг гучин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга, мөн Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төвийн хуучин барилгыг буулгаж, шинээр нийслэлийн хүүхдийн сэргээн засах төвийн барилга барих болсонтой холбогдуулан тус газрын баланст бүртгэлтэй, нийт 44,829,054.00 (дөчин дөрвөн сая найман зуун хорин есөн мянга тавин дөрвөн) төгрөгийн хавсралтад дурдсан барилгуудыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.


2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн  
114 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Сонгинохайрхан дүүргийн Гурванцүүр өрхийн эрүүл мэндийн төвийн барилга	2001	Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо /ханын материалын эцэс/	64,994,142.30	13,648,769.82	51,345,372.48	Нийслэлийн Хяналт шалгалтын газрын улсын ахлах байцаагчийн 2024 оны 02-13-01/027/63 дугаар дүгнэлт
2	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төвийн барилга	1962	Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо /Үйлдвэрчний эвлэлийн гудамж, Москва-41-1 тоот/	44,829,054.00	44,829,054.00	0	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2010 оны 07-276/141 дүгээр дүгнэлт
НИЙТ ДҮН				109,823,196.30	58,477,823.82	51,345,372.48	